



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/372

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170, 2018 оны 316 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын техникийн хяналтын зардлаас 8 639 600 төгрөг /найман сая зургаан зуун гучин ес мянга зургаан зуун/-ийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө , хөгжлийн бодлого, төвлөлтийн хэлтсийн албан хэрэгцээнд компьютер, техник хэрэгсэл худалдан авахад зарцуулсугай.

2. Эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Жаргалант сумын Цамбагарав багийн 9-н давхар улаан 80 айлын орон сууцны гадна шугам сүлжээний шинэчлэлийн ажилд зориулан 31 390 000 /гучин нэгэн сая гурван зуун ерэн мянган/ төгрөгийг санхүүжүүлэхийг зөвшөөрч, төсөвт тусгах замаар буцаан төвлөрүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

3. Албан хэрэгцээнд худалдан авах компьютер, техник хэрэгслийг нэгдүгээр хавсралтаар, Жаргалант сумын Цамбагарав багийн 9-н давхар улаан 80 айлын орон сууцны гадна шугам сүлжээний шинэчлэлийн ажлын тоо хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Дээрх арга хэмжээний зардлыг Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын техникийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01626  
D/Zah-A/372- Bo

Аймгийн Засаг даргын 2020 оны  
07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/372 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт




ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД  
КОМПЬЮТЕР, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ  
ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

№	Компьютер, техник хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Компьютер /i7 dell/	4	1 989 900	7 959 600
2.	Принтер /Epson l5658 3 үйлдэлтэй А3/	1	680 000	680 000
Нийт дүн				8 639 600

- оОо-

Аймгийн Засаг даргын 2020 оны  
07 дугаар сарын 07-ны өдрийн  
А/372 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт



ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР УЛААН 80 АЙЛЫН  
ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ГАДНА ШУГАМЫН  
АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

№	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Ф 150 ган хоолой гагнах	м	100*2=200	40000	8 000 000
2.	Ф 150 бөмбөлгөн хаалт гагнах	ш	4	200000	800 000
3.	Ф 150 отвод гагнах	ш	8	30000	240 000
4.	Гадна сувгийн 1,70м2 хавтан	Хавтан	100	35000	3 500 000
5.	Суваг ухах	м	100	20000	2 000 000
6.	Өрлөг хийх 2 үе блок өрөх	ш	2000	1800	3 600 000
7.	Цементээр ул цутгах	кг	400	17000	6 800 000
8.	Гагнуурын хөлс	Ф150	50	40000	2 000 000
9.	Трактор ажиллуулах	1м	100	20000	2 000 000
10.	Цалин хөлс	хүн	5	35000	1 750 000
11.	Бусад зардал				700 000
Нийт дүн					31 390 000

- оОо-